



**ШҮҮХИЙН ШИНЭТГЭЛИЙН ЯВЦ, ҮР ДҮН, ШҮҮХИЙН  
ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР  
БҮХ ШАТНЫ ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧДЭЭС АВСАН  
САНАЛ АСУУЛГЫН СУДАЛГАА**

Улаанбаатар хот  
2016 он

## Удиртгал

Шүүхийн ерөнхий зөвлөл Монгол Улсын бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгчдийн дунд Шүүхийн ерөнхий зөвлөлийн тайланг 2015 оны 2 дугаар сарын 5-ны өдөр хэлэлцүүлсэн. Шүүхийн ерөнхий зөвлөл Шүүхийн тухай багц хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд өнгөрсөн гурван жилийн хугацаанд хийсэн шүүхийн шинэтгэлийн үйл явц, үр дүн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааны тайланг нийт шүүхийн Ерөнхий шүүгчдэд танилцуулж, тэдгээрийн санал хүсэлтийг сонссон болно. Энэ хүрээнд Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс хэлэлцүүлэгт оролцсон шүүгчдээс шүүхийн шинэтгэлийн үр дүн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагаа, шүүхийн хөгжлийн бодлогын асуудлаар санал асуулгын судалгааг авч гүйцэтгэв.

Дээрх зорилгын хүрээнд дараах чиглэлээр анкет боловсруулан мэдээлэл цуглуулсан.

Үүнд:

- Шүүн таслах ажиллагааны чанар, үр өгөөж;
- Дагнасан шүүхийн тогтолцоо, зохион байгуулалтын өөрчлөлтүүд;
- Шүүхийн тамгын газрын үйл ажиллагаа;
- Шүүхийн захиргааны үйл ажиллагаа;
- Шүүгчийн ёс зүй, хариуцлага;
- Шүүхийн шинэтгэлийн явц, үр дүн;
- Шүүхийн шинэтгэлд тулгарч буй бэрхшээл, цаашид анхаарах чиглэл зэрэг болно.

## 1. Судалгаанд оролцсон Ерөнхий шүүгчдийн ерөнхий мэдээлэл

### Хүснэгт №1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл


№	Утга	Тоололт	Хувь
<b>Аль шатны шүүхийн шүүгч</b>			
1	Анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч / түр орлон гүйцэтгэгч	65	79,3
2	Давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч / түр орлон гүйцэтгэгч	17	20,7
<b>Шүүгчээр ажилласан жил</b>			
1	1-5 жил	5	6,1
2	6-10 жил	17	20,7
3	11-15 жил	27	32,9
4	16-аас дээш жил	33	40,2
5	Бүгд	82 <sup>1</sup>	100

Судалгаанд оролцогчдын 79,3 хувь нь буюу 65 нь анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, 20,7 хувь нь буюу 17 нь давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч байсан байна. Шүүгчдийн 6,1 хувь нь 5 хүртэл жил, 20,7 хувь нь 6-10 жил, 32,9 хувь нь 11-15 жил, 40,2 хувь нь 16-аас дээш жил тус тус шүүгчээр ажилласан байна.

<sup>1</sup> Нэг шүүгч аль шатны шүүгч болох, хэдэн жил ажилласанаа хариулаагүй болно.

## 2. Шүүн таслах ажиллагааны чанар, үр нөлөө


График № 1. Шүүн таслах ажиллагааны чанар, үр нөлөө




Шүүн таслах ажиллагааны чанар, үр нөлөөний өнөөгийн байдлыг судалгаанд оролцсон Ерөнхий шүүгчдийн 6 хувь нь “маш сайн”, 71 хувь нь “сайн”, 9 хувь нь “хангалтгүй” гэж үнэлсэн бол 14 хувь нь “хэлж мэдэхгүй” гэж хариулжээ.

## 3. Дагнасан шүүхийн тогтолцоо, зохион байгуулалтын өөрчлөлтүүд


График № 2. Дагнасан шүүхийн тогтолцоонд шилжсэн нь




Шүүхүүд хэрэг, маргааны төрлөөр дагнан байгуулагдаж, дагнасан шүүхийн тогтолцоонд шилжсэнийг судалгаанд оролцсон Ерөнхий шүүгчдийн 55 хувь нь шүүгч мэргэших нөхцөл бүрдсэн, 39 хувь нь бүхэлдээ оновчтой зохион байгуулалт болсон, 5 хувь нь хэргийн ачаалал жигдэрсэн гэж үзсэн бол 1 хувь нь шүүх иргэдээс холдсон гэж хариулсан байна. Үүнээс харахад нийт судалгаанд оролцсон шүүгчдийн дийлэнх нь хэрэг маргааны төрлөөр дагнаж байгаа нь зөв гэж үзсэн байна.

**График № 3. Дагнасан шүүх байгуулсан нь шүүхийн шийдвэрийн чанарт ахиц гарсан**

Шүүхийг хэрэг, маргааны төрлөөр дагнан байгуулсан нь шүүхийн шийдвэрийн чанарт эерэгээр нөлөөлсөн, ахиц гарсан гэдэгтэй Ерөнхий шүүгчдийн 56 хувь нь “бүрэн санал нийлж байна”, 34 хувь нь “санал нийлж байна”, 10 хувь нь “зарим талаар санал нийлж байна” гэж үзсэн бол мэдэхгүй болон санал нийлэхгүй байна гэсэн саналтай Ерөнхий шүүгч байхгүй байна.


**График № 4. Шүүгчийн цалин хөлсийг нэмэгдүүлсэн нь (хувиар)**

Шүүгчийн эдийн засгийн хараат бус байдлыг дээшлүүлэх, цалин хөлсийг нэмэгдүүлснийг судалгаанд оролцсон Ерөнхий шүүгчдийн 81,9 хувь нь “нийгмийн баталгаа болсон”, 72,3 хувь нь “хариуцлагатай ажиллах сэдэл болсон”, 65,1 хувь нь “шүүхийн хүний нөөцөд өрсөлдөөн бий болгосон” гэж үзжээ.

**График № 5. Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх болсноор**


Шүүгч, шүүх бүрэлдэхүүн нөлөөллийн мэдүүлэг хөтлөх болсон нь шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөх явдал эрс буурсан гэж судалгаанд оролцсон Ерөнхий шүүгчдийн 84 хувь нь үзсэн бол 5 хувь нь өөрчлөлт гараагүй, 11 хувь нь хариулж мэдэхгүй байна гэж тус тус хариулжээ.

**График № 6. Тахарын алба үйл ажиллагаа явуулснаар шүүх, шүүгчийн аюулгүй байдал хангагдсан**




Тахарын алба байгуулагдан үйл ажиллагаагаа явуулснаар шүүх, шүүгчийн аюулгүй байдал хангагдсан талаар Ерөнхий шүүгчдийн 52 хувь нь “тийм, бүрэн хэмжээгээр хангагдсан”, 46 хувь нь “зарим талаар ахиц гарсан”, 2 хувь нь “зарим талаар дутагдалтай байна” гэж үзжээ.

**График № 7. Шүүхэд итгэх олон нийтийн итгэл дээшилсэн**



Шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангаснаар шүүхэд итгэх олон нийтийн итгэл дээшилсэн эсэхийг Ерөнхий шүүгчдийн 73 хувь нь “тийм, иргэдийн итгэлийг дээшлүүлсэн”, 23 хувь нь “зарим талаар дээшлүүлсэн”, 4 хувь нь “зарим талаар дутагдалтай байна” гэж үзжээ. Үүнээс харахад шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангасан нь олон нийт шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлж байна гэж шүүгчдийн дийлэнх олонх нь үзсэн байна.

**График № 8. Шүүхэд хэргийн хөдөлгөөний удирдлагын програм хангамж, тогтолцоог нэвтрүүлснээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүтээмж, хариуцлага дээшилсэн**



Шүүхэд хэргийн хөдөлгөөний удирдлагын програм хангамж, тогтолцоог нэвтрүүлснээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүтээмж, хариуцлагатай байдал дээшилсэн талаар шүүгчдийн 68 хувь нь “бүрэн санал нийлж байна”, 31 хувь нь “зарим талаар санал нийлж байна”, 1 хувь нь “мэдэхгүй” гэж хариулсан бол санал нийлэхгүй байгаа Ерөнхий шүүгч байхгүй байна.


**График № 9. Шүүхийн бус журмаар хэрэг маргаан шийдвэрлэх ажиллагааны хүрээг өргөтгөх талаар**



Судалгаанд хамрагдсан Ерөнхий шүүгчид шүүхийн бус журмаар хэрэг, маргааныг шийдвэрлэх ажиллагааны хүрээг өргөтгөх талаар 69,1 хувь нь шүүхийн ачааллыг багасгах ач холбогдолтой тул дэмждэг, 25,9 хувь нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохих түвшинд нэвтрүүлэх нь хэрэгтэй байна, 24,7 хувь нь зөвхөн иргэний хэргээр хязгаарлах нь зүйтэй, 21 хувь нь захиргааны хэрэг, маргаанд нэвтрүүлж шүүхийн ачааллыг хөнгөвчлөх нь зүйтэй гэж үзэж буйгаа илэрхийлжээ. Үүнээс харахад шүүхийн бус журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээг өргөтгөснөөр шүүхийн ажлын ачааллыг хөнгөвчлөх боломжтой гэж судалгаанд оролцсон дийлэнх шүүгчид үзсэн байна.

#### **4. Шүүхийн тамгын газрын үйл ажиллагаа**

График № 10. Тамгын газрын үйл ажиллагааны ерөнхий үнэлгээ



Судалгаанд хамрагдсан Ерөнхий шүүгчид өөрийн шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны өнөөгийн байдлыг 21 хувь нь хангалттай сайн, 49 хувь нь хэвийн, 24 хувь нь доголдолтой байгаа, 6 хувь нь хангалтгүй гэж үнэлсэн байна. Харин тамгын газрын үйл ажиллагааны нарийвчилсан үнэлгээг дараах байдлаар гаргажээ. /Хүснэгт №2/

Хүснэгт №2. Шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны нарийвчилсан үнэлгээ

№	Шалгуур	Сайн	Дунд	Муу
1	Ажилтнуудын хариуцлага дэг, журам	53.0%	44.6%	2.4%
2	Ажилтнуудын ажлын мэдлэг, ур чадвар	28.9%	63.9%	7.2%
3	Ажилтнуудын цаг ашиглалт, зохион байгуулалт	54.2%	39.8%	6.0%
4	Шийдвэрийн ил тод, шударга байдал	79.0%	17.3%	3.7%
5	Ажиллагсдын сэтгэл ханамж	56.2%	42.5%	1.2%
6	Шүүгчийн хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлсэн байдал	56.6%	41.0%	2.4%
7	Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангасан байдал	59.0%	37.3%	3.6%
8	Шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах байдал	47.5%	47.5%	5.0%
9	Шүүхийн хэвийн ажиллах эдийн засаг, хүний нөөц, зохион байгуулалтын нөхцөл боломжийг бүрдүүлсэн байдал	41.5%	52.4%	6.1%

Судалгаанд хамрагдсан Ерөнхий шүүгчид шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны хамгийн сайн үйл ажиллагааг дараах байдлаар үнэлжээ. Үүнд:

1. Шийдвэрийн ил тод, шударга байдал (79%);
2. Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангасан байдал (59%);
3. Шүүгчийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байдал (56,6%).

Харин Ерөнхий шүүгчид дараах асуудалд анхаарах шаардлагатай гэж үзсэн буюу хангалтгүй үнэлгээг өгчээ. Үүнд:

1. Ажилтнуудын ажлын мэдлэг, ур чадвар (28,9%);
2. Шүүхийн хэвийн ажиллах эдийн засаг, хүний нөөц, зохион байгуулалтын нөхцөл боломжийг бүрдүүлсэн байдал (41,5%);
3. Шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах байдал (47,5%).

## 5. Шүүхийн захиргааны үйл ажиллагаа

**Хүснэгт №3. Шүүхийн захиргааны үйл ажиллагаанд өгч буй ерөнхий үнэлгээ**

№	Үйл ажиллагааны чиглэл	Сайн	Дунд	Муу
1	Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах	93.7%	6.3%	.0%
2	Шүүхийн захиргааны удирдлага, зохион байгуулалт	70.9%	27.8%	1.3%
3	Шүүхийн хэргийн хөдөлгөөний удирдлага	80.2%	19.8%	.0%
4	Шүүхийн хүний нөөцийн удирдлага	58.0%	40.7%	1.2%
5	Шүүгчийн сонгон шалгаруулалт	79.7%	20.3%	.0%
6	Шүүхийн санхүү, хөрөнгө оруулалт	67.9%	32.1%	.0%
7	Шүүхийн хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах чиг үүрэг	81.5%	16.0%	2.5%
8	Шүүхийн судалгаа, мэдээлэл /Ном, сэтгүүл, гарын авлага г.м/	86.4%	13.6%	.0%
9	Шүүхийн сургалт	63.8%	35.0%	1.2%
10	Шүүхийн гадаад харилцаа	56.4%	39.7%	3.8%


Судалгаанд хамрагдсан Ерөнхий шүүгчид Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүхийн захиргааны чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаанаас хамгийн сайн чиглэл, үйл ажиллагааг дараах байдлаар үнэлжээ. Үүнд:

1. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах (93,7%);
2. Шүүхийн судалгаа, мэдээлэл (86,4%);
3. Шүүхийн хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах чиг үүрэг (81,5%).

Харин Ерөнхий шүүгчид дараах асуудалд анхаарах шаардлагатай буюу бусдаасаа бага үнэлгээг өгчээ. Үүнд:

1. Шүүхийн гадаад харилцаа (56,4%);
2. Шүүхийн хүний нөөцийн удирдлага (58%);
3. Шүүхийн сургалт (63,8%).

**График № 11. Шүүх цахимжих шаардлагатай эсэх**




Цахим гарын үсгийн тухай хууль болон бусад холбогдох хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор шүүхэд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлж, цахим шүүх болох шаардлагатай талаар Ерөнхий шүүгчдийн 68 хувь нь “тийм”, 31 хувь нь “хэлж мэдэхгүй байна”, 1 хувь нь “үгүй” гэж хариулсан байна.



## 6. Шүүгчийн ёс зүйн хариуцлага

График № 12. Шүүгчдийн сахилга, хариуцлага, ёс зүйн түвшин



Нийт шүүгчдийн сахилга, хариуцлага, ёс зүйн түвшнийг Ерөнхий шүүгчид үнэлэхдээ 4 хувь нь “маш сайн”, 73 хувь нь “сайн”, 17 хувь нь “хэлж мэдэхгүй байна”, 6 хувь “тааруу байна” гэж тус тус үнэлсэн байна.


График № 13. Шинэ шүүгчдийн хувьд ямар мэдлэг, чадвар, дадал эзэмшсэн байх шаардлагатай талаар



Судалгаанд хамрагдсан Ерөнхий шүүгчид шинээр томилогдож буй шүүгчдийн хувьд хамгийн тэргүүнд дараах мэдлэг, чадвар, дадал, эзэмших шаардлагатай гэж хариулжээ. Үүнд:

1. Шүүгчээр ажиллах зан төлөвийг анхаарах (82,9%);
2. Хууль зүйн мэдлэг, хууль хэрэглээний чадвар (76,8%);
3. Ёс зүйд анхаарах (70,6%);
4. Харилцааны соёл (56,1%);
5. Сайн шийдвэр бичих ур чадвар (51,2%).

График № 14. Дэд бүтэц, тоног төхөөрөмж, эд хогшил, багаж хэрэгсэл хүртээмжтэй эсэх




Шүүн таслах ажиллагаа хэвийн явагдахад дэд бүтэц, тоног төхөөрөмж, эд хогшил, багаж хэрэгсэл хүртээмжтэй, хангалттай эсэх талаар судалгаанд хамрагдсан Ерөнхий шүүгчдийн 59 хувь нь хангалттай буюу “тийм” гэсэн бол 29 хувь нь “үгүй” гэж хариулжээ. Ямар тоног төхөөрөмж, эд хогшил, багаж хэрэгсэл хэрэгтэй байгаа талаар нээлттэй байдлаар:

- ❖ Нотлох эд мөрийн баримт судалдаг техник;
- ❖ Олон үйлдэлтэй хэвлэх машин;
- ❖ Цахимаар хэргийн оролцогчтой харилцах төхөөрөмж бүрэн хэрэгтэй;
- ❖ Шүүхийг шинэ байраар хангах;
- ❖ Сейф... зэргийг бичжээ.

## 7. Шүүхийн шинэтгэлийн явц, үр дүн

График № 15. Шүүхийн шинэтгэлийн 10 үр дүнгийн хамгийн чухал нь



Шүүхийн шинэтгэлийн хүрээнд хийгдсэн 10 үйл ажиллагаа, үр дүнгээс Ерөнхий шүүгчид хамгийн чухал ажил холбогдолтой болсныг 1. Мэргэшсэн шүүх, шүүгч (86,1%), 2. Шүүхийн эрх зүй (59,5%), 3. Шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдал, шүүхэд итгэх илтгэл


зэрэг нь тус тус 58,2 хувиар жагссан бол хамгийн бага үнэлгээг хүний нөөцийн шинэтгэл (20,3%) авсан байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2016 онд зохион байгуулах сургалтын хүрээнд ямар сэдвээр сургалт явуулах нь зүйтэй талаар:

- ❖ Эрүүгийн эрх зүй:
  - Шинээр батлагдсан эрүүгийн хууль.
- ❖ Эрүүгийн процессын эрх зүй:
  - Процессын шинэ хууль;
  - Шүүх хуралдаан даргалан явуулах ажиллагаа.
- ❖ Иргэний эрх зүй:
  - Гэрээний эрх зүй;
  - Олон улсын хувийн эрх зүй;
  - Татвар, гааль, худалдаа, оюуны өмчийн эрх зүй;
  - Үүргийн эрх зүй.
- ❖ Иргэний процессын эрх зүй:
  - Нотлох баримт гаргах;
  - Хууль тайлбарлах;
  - ХХША-нд гарч буй нийтлэг алдаа;
  - Хэргийн хөдөлгөөний программ.
- ❖ Захиргааны эрх зүй:
  - Сонгуулийн тухай хууль;
  - Захиргааны ерөнхий хууль буюу шинэ батлагдсан хууль.
- ❖ Захиргааны процессын эрх зүй:
  - ЗХШХШТХ;
  - Шинэ процессын хууль.
- ❖ Салбар дундын мэдлэг:
  - Татвар, банк санхүү, нийгмийн даатгал, өрсөлдөөн, худалдааны эрх зүй.
- ❖ Бусад:
  - Ёс зүй;
  - Сэтгэл зүй;
  - Нийгмийн мэдрэмж;
  - Төр эрх зүйн онол;
  - Гадаад хэл.




График № 16. Шүүхийн шинэтгэлийн үйл явц, үр дүнгийн үнэлгээ



Судалгаанд оролцсон Ерөнхий шүүгчдийн 44 хувь нь шүүхийн шинэтгэлд “маш сайн” буюу 5 оноо, 55 хувь нь “сайн” буюу 4 оноо, 1 хувь нь “дунд” буюу 3 оноог тус тус өгсөн байна.

График № 17. Шүүхийн шинэтгэлд тулгарч буй саад, бэрхшээл



Ерөнхий шүүгчид шүүхийн шинэтгэлд 1. Шинэтгэлийг дэмжих улс төрийн соёл, дэмжлэг бүрдээгүй (80.5%), 2. Шүүхийн дэд бүтэц, санхүү хөрөнгө оруулалт дутмаг (46,8%), 3. Шүүхийн эдийн засгийн баталгаа дутмаг (41,6%) зэрэг нь түлхүү нөлөө үзүүлж саад, бэрхшээл үзүүлж байна гэж үзсэн байна.

## 8. Шүүхийн шинэтгэлд тулгарч буй бэрхшээл, цаашид анхаарах чиглэл

**Хүснэгт №4. Шүүхийн шинэтгэл цаашид юунд анхаарах шаардлагатай вэ?**

№	Шинэтгэлийн чиглэл	Маш чухал	Чухал	Чухал биш	Мэдэхгүй
1	Шүүгчийн хараат бус байдлын баталгааг нэмэгдүүлэх	64.9%	32.4%	2.7%	.0%
2	Хууль тогтоомжийг шинэтгэх	36.2%	58.0%	4.3%	1.4%
3	Шүүхийг улс төрийн, эдийн засгийн, танил тал гэх мэт хөндлөнгийн нөлөөнөөс хамгаалах	61.4%	32.9%	5.7%	.0%
4	Шүүгч, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх	73.7%	26.3%	.0%	.0%
5	Шүүгчийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэх	70.7%	25.3%	4.0%	.0%
6	Шүүхийн захиргааны ажилтны сахилга, хариуцлагыг дээшлүүлэх	68.5%	30.1%	1.4%	.0%
7	Шүүгчийг маргааны төрлөөр мэргэшүүлэх	59.5%	28.4%	12.2%	.0%
8	Шүүгч, ажилтнуудын зан харилцааг сайжруулах	53.4%	43.8%	1.4%	1.4%
9	Шүүхийн үйл ажиллагааг цахим болгох	40.0%	54.3%	5.7%	.0%
10	Шүүх дэх иргэдийн төлөөлөгчийн оролцоог дэмжих	17.4%	60.9%	17.4%	4.3%
11	Шүүхийн барилга байгууламжийг сайжруулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр нь хангах	63.0%	31.5%	2.7%	2.7%
12	Шүүхэд тавих иргэдийн хяналтыг нэмэгдүүлэх	24.6%	62.3%	10.1%	2.9%
13	Маргааныг эвийн журмаар, харилцан тохиролцож шүүхээс гадуур шийдвэрлэх тогтолцоог өргөжүүлэх	49.3%	46.5%	4.2%	.0%
14	Мэдээллийн ил тод байдлыг хангах	35.7%	57.1%	5.7%	1.4%

Ерөнхий шүүгчид цаашид шүүхийн шинэтгэлийн хүрээнд дараах чиглэлд анхаарч ажиллах шаардлагатай гэж үзжээ. Үүнд:

1. Шүүгч, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх (73.7%);
2. Шүүгчийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэх (70,7%);
3. Шүүхийн захиргааны ажилтны сахилга, хариуцлагыг дээшлүүлэх (68,5%);
4. Шүүгчийн хараат бус байдлын баталгааг нэмэгдүүлэх (64,9%);
5. Шүүхийн барилга байгууламжийг сайжруулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр нь хангах (63%) зэрэг болно.

### Дүгнэлт

Бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгчдэд Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2015 оны тайлан хэлэлцүүлэх үеэр авсан санал асуулгыг 83 Ерөнхий шүүгчээс авч тайлагналаа. Үүнээс 17 нь давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, 65 нь анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч байв.

Санал асуулгын үр дүнд шүүн таслах ажиллагааны чанар, үр өгөөж, дагнасан шүүхийн тогтолцоо, зохион байгуулалтын өөрчлөлтүүд, шүүхийн тамгын газрын үйл ажиллагаа, шүүхийн захиргааны үйл ажиллагаа, шүүгчийн ёс зүй, хариуцлага, шүүхийн шинэтгэлийн явц, үр дүн, шүүхийн шинэтгэлд тулгарч буй бэрхшээл, цаашид анхаарах чиглэл зэрэгт дараах үнэлгээ, саналын авлаа. Үүнд:

- Шүүн таслах ажиллагааны чанар, үр өгөөжийг Ерөнхий шүүгчдийн 77 хувь нь сайн болон маш сайн гэж үнэлж байна. Харин 15 хувь нь хангалтгүй буюу цаашид сайжруулах, анхаарах шаардлагатай гэж үзжээ. Өнгөрсөн жил буюу 2014 онд шүүн таслах ажиллагааны чанар үр өгөөж хангалтгүй буюу дунд гэж 60 хувь нь үзэж байсан бол энэ жил 15 хувь болж 45 хувиар буурсан байна.
- Дагнасан шүүхийн тогтолцоонд шилжсэнийг Ерөнхий шүүгчдийн 99 хувь нь эерэгээр үнэлэхийн зэрэгцээ шүүхийн шийдвэрийн чанарт ахиц гарсан гэж 90 хувь нь хүлээн зөвшөөрсөн байна.
- Шүүгчдийн цалинг нэмснээр шүүгчдэд ажиллах, амьдрах нийгмийн баталгаа болж байна гэж 81,9 хувь нь үзсэн бол нөлөөллийн мэдүүлэг хөтлөх болсноор шүүгчдийн хараат бус байдалд нөлөөлөх явдал эрс буурсан гэж 84 хувь нь үзсэн байна. Мөн тахарын алба үйл ажиллагаа явуулснаар шүүгчийн аюулгүй байдал бүрэн хангагдаж байна гэж 52 хувь нь үзэхийн зэрэгцээ шүүхэд итгэх олон нийтийн итгэл шүүхийн шинэтгэл явагдаж эхэлснээс хойш дээшилсэн гэж 73 хувь нь үзэж байна.
- Шүүхийн бус журмаар хэрэг, маргаан шийдвэрлэх ажиллагааг өргөтгөх нь ач холбогдолтой гэж Ерөнхий шүүгчдийн 69,1 хувь нь дэмжээд үүнийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохих түвшинд нэвтрүүлэх нь зүйтэй гэж 25,9 хувь нь, захиргааны хэрэг маргаанд нэвтрүүлэх нь зүйтэй гэж 21 хувь нь, зөвхөн иргэний хэргээр хязгаарлах нь зөв гэж 24,7 хувь нь тус тус үзэж байна.
- Ерөнхий шүүгчдийн 70 хувь нь тамгын газрын үйл ажиллагааг хэвийн бөгөөд хангалттай сайн, 30 хувь нь доголдолтой бөгөөд хангалтгүй байна гэж үнэлжээ. 2014 онд 61 хувь нь хэвийн бөгөөд сайн, 39 хувь нь доголдолтой бөгөөд хангалтгүй гэж үнэлсэн байснаас үзвэл энэ удаад хангалтгүй байгаа байдал буурсан буюу 9 хувийн үзүүлэлтээр тамгын газрын үйл ажиллагаа өсч сайжирсан байна. Харин хангалтгүй байгаа шалтгаан буюу нарийвчилсан үйл ажиллагааны чиглэлүүдэд 1.Ажилтнуудын мэдлэг ур чадвар; 2.Шүүхийн хэвийн ажиллах эдийн засаг, хүний нөөц, зохион байгуулалтын нөхцөл

- боломжийг бүрдүүлсэн байдал; 3.Шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах байдал зэрэгт цаашид анхаарал хандуулах шаардлагатай байна гэж үзжээ.
- Шүүхийн захиргааны үйл ажиллагаанд Ерөнхий шүүгчид 1.Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, 2.Шүүхийн судалгаа, мэдээлэл, 3.Шүүхийн хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах чиг үүрэг зэрэгт “сайн” үнэлгээ өгсөн бол шүүхийн гадаад харилцаа, шүүхийн хүний нөөцийн удирдлага, шүүхийн сургалт зэрэг чиг үүрэгт цаашид анхаарах, сайжруулах шаардлагатай буюу бусдаас бага үнэлгээ өгчээ.
  - Ерөнхий шүүгчид нийт шүүгчдийн ёс зүйн түвшин хандлагыг 4 хувь нь “маш сайн”, 73 хувь нь “сайн”, харин 10 хувь нь “тааруу” болон “муу” гэж үнэлсэн байна. Цаашид шинээр шүүгч болж байгаа хуульчдад 1.Шүүгчээр ажиллах зан төлөв, 2.Хууль зүйн мэдлэг, хууль хэрэглээний чадвар, 3.Ёс зүй, 4.Харилцааны соёл, 5.Сайн шийдвэр бичих ур чадвар зэрэг шалгуурыг тэргүүн ээлжид тавих шаардлагатай байна гэж үзжээ.
  - Дэд бүтэц, тоног төхөөрөмж, эд хогшил, багаж хэрэгслийг Ерөнхий шүүгчдийн 59 хувь нь “хангалттай” гэсэн бол 29 хувь нь “учир дутагдалтай байна” гэж үзээд нотлох эд мөрийн баримт судалдаг техник, олон үйлдэлтэй болон хувилагч, хэвлэгч машин, сейф зэрэг дутагдаж байна гэж хариулжээ.
  - Шүүхийн шинэтгэлийн 10 үр дүнгийн хамгийн чухлыг мэргэшсэн шүүх, шүүгч гэж үзээд анхаарах шаардлагатай үр дүнг хүний нөөцийн шинэтгэл гэж үзжээ.
  - 2016 онд зохион байгуулах сургалтын хүрээнд шинээр батлагдсан эрүүгийн болон захиргааны материаллаг хууль, эрүү, захиргааны процессын хуулийн тайлбар, мэдээллийг агуулсан сургалтыг явуулах, мөн сонгуулийн хууль, татвар, банк санхүү, нийгмийн даатгал, өрсөлдөөн, худалдааны эрх зүй зэрэг сэдвээр сургалт явуулах хэрэгтэй гэж үзжээ.
  - Эцэст нь, шүүхийн шинэтгэлийн явц үр дүнд Ерөнхий шүүгчдийн 99 хувь нь “сайн” болон “маш сайн” гэсэн үнэлгээ өгөөд шүүхийн шинэтгэлд цаашид 1.Шүүгч, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, 2.Шүүгчийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, 3.Шүүхийн захиргааны ажилтны сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, 4.Шүүгчийн хараат бус байдлын баталгааг нэмэгдүүлэх, 5.Шүүхийн барилга байгууламжийг сайжруулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр нь хангах зэрэг чиглэлд анхаарч ажиллах шаардлага байна гэж үзсэн байна.